



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 21 өдөр

Дугаар А/210

Есөнбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1 дэх заалт, Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаар хуралдааны шийдвэр, аймгийн Онцгой комиссын 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 05 хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд нийт нутаг дэвсгэрт өвөлжилт, хаваржилт хүндэрч байгаатай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалангаар ахлуулсан ажлын хэсэг тус аймагт 2 удаа ажилласантай холбогдон гарсан 15.861.200 (арван таван сая найман зуун жаран нэгэн мянга хоёр зуу) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын гамшгаас хамгаалах орон нутгийн нөөц сангаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав), Санхүү төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

8200010709

Аймгийн Засаг даргын 2024 оны  
05 дугаар сарын 21-ны өдрийн 40 дүгээр  
захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Буудлын зардал	4 хоног	2,240,300	8,961,200
2	Хоол, цайны материал	60 хүн	115,000	6,900,000
Нийт				15,861,200

\_\_оОо\_\_

